



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024.05.22 № 01/971

танай _____-ны № _____-т

Тендер түдгэлзүүлэх тухай

Танай төвөөс зарласан “Эм, эмнэлгийн хэрэгсэл” БГДЭМТ/20240102003 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичгийн Багц 6-д “Агниста фарм” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянаж байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсэгт заасны дагуу гомдлыг хянан шийдвэрлэх хүртэлх хугацаанд уг тендерийн Багц 6-ийн шалгаруулалттай холбогдуулан гаргасан захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилт, тендер хүлээн авах, нээлт хийх үйл ажиллагааг түдгэлзүүлж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Тус газарт тендерийн баримт бичиг, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл болон бусад холбогдох шаардлагатай баримт бичгийг албан бичгээр болон цахим шуудангаар (munkhbat@afccp.gov.mn) 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА



Б.БИЛГҮҮН

0002080